



### Зориулалт

Шилэн барилгын угсралт, хаалганы блок, цонхны тавцан, хананы хавтанг бэхлэх, хагарал болон хоосон зайг чигжих, завсарын дулаан болон дүү чимээ тусгаарлах түүнчлэн бусад барилга угсралт, өнгөлгөө, угсралтын ажилд зориулагдсан. Өндөр чанарын нэг бүрэлдэхүүнт полиуретан угсралтын хөөс нь бетон, тоосго, гипс, мод, хуванцар гэх мэт полиэтилен, полипропилен, фторопластикаас бусад барилгын ихэнх материалд маш сайн наалдаж өгдөг. Нэгэн жигд, тогтвортой гаралтыг хангаж, бэлэн болсон хөөс нь гайхалтай нятралтай бүтцийг бий болгодог. Маш сайн дулаан болон дүү чимээ тусгаарлагч үүсгэдэг. Хоёрдогч тэлэлт байхгүй учир хийцийг деформацид оруулдаггүй.

### Хэрэглэх заавар

- Ажиллаж эхлэхийн өмнө бууны адаптерийн сагсан дахь хавхлагын суудлыг сайтар цэвэрлэсэн эсэхийг шалгах хэрэгтэй. Үгүй бол хавхлагын дутуу ажиллагаа үүсч болно.
- Ажлыг -25°C-аас +30°C хүртэл температурт, агаарын харьцангуй чийгшил 50%-аас доошгүй үед хийхийг зөвлөж байна.
- Хөөсийн физик-механикийн үзүүлэлтүүдийн оновчтой байдал болон их хэмжээгээр гаргахын тулд баллоны температурыг хүснэгтийн дагуу мөрдөхийг зөвлөж байна.
- Цэвэрхэн ажиллахын тулд зэргэлдээх гадаргууг будагын скочоор хучихыг зөвлөж байна.
- Урьдчилж тоос, шавар, тос, мөс, цан зэрэг бохирдлыг цэвэрлэсэн гадаргуу дээр хөөсийг хэрэглэнэ.
- Хөөсийг хэрэглэхээс өмнө ажиллах гадаргууг чийгшүүлнэ. Орчны температур 0°C-ээс дээш тохиолдолд ус, 0°C-ээс доош тохиолдолд «Активатором монтажной пены» "Угсралтын хөөс идэвхжүүлэгч" хэрэглэнэ.
- Баллоныг доош харуулсан байдалтай ажиллана. Хамгаалалтын тагийг савнаас авна.
- Бууг Х- хэлбэртэй цорго руу эргүүлж шургуулна. Найдвартай холбогдсон эсэхийг шалгана.
- Баллоныг 30 секундын турш 15-аас доошгүй удаа сайтар сэгсэрнэ.
- Угсралтын хөөсийг доороос дээш чиглэлтэйгээр хагархайн 2/3 хэсгийг дүүргэж түрхэнэ.
- Бууны эргийн тусламжтайгаар хөөсийн гаралтыг тохируулна.
- Ашиглалтын явцад баллоныг тогтмол сэгсэрнэ.
- Хэрэглэсний дараа хөөсийг орчны 0° С-ээс дээш температурт шуршигчийн тусламжтай усаар чийгшүүлнэ.
- Бүрэн хатуурсны дараа илүүдэл хөөсийг хутгаар зүсэж авна.
- Хатаагүй хөөсийг «Очистителем монтажной пены» "Угсралтын хөөс цэвэрлэгч" ашиглан арилгана.
- Хатуурсан хөөсөнд «Удалитель застывшей монтажной пены» "Хатсан угсралтын хөөс арилгагч" хэрэглэнэ.
- Бүрэн полимержилтын дараа (24-48 цаг) хатуурсан хөөсийг зүсэж, гипсдэж, будаж болно.
- Хэт ягаан туяа болон хур тунадасын нөлөөллөөс хамгаална.

Өнгө	Цагаан
Хөөсийн гаралт	65/70 литр хүртэл*
Зүсэлтийн бүтэц	нэгэн төрлийн нарийн сүвэрхэг
Хоёрдогч тэлэлч	15-30%
Арьс үүсэх хугацаа	10 минут*
Үндсэн боловсруулалтын хугацаа	20 минут*
Бүрэн полимержих хугацаа	24-48 цаг*
Нятрал	10-20 кг/м3
Орчны температур	-25 °C ... +30 °C
Баллоны температур	-10 °C ... +30 °C
Хатуурсан хөөсийн дулаан тэсвэрлэх чадвар	-40 °C ... +90 °C
Хадгалах температур	+5 °C ... +25 °C

\* +23 °C температурт, агаарын харьцангуй чийгшил 50 %

#### KUDO өвлийн хөөсийг хэрэглэх температурын горим:

Орчны температур	20°C	0° C	-10° C	-25° C
Баллоны температур	+18 °C ... +22 °C	+15 °C ... +18 °C	+10 °C ... +15 °C	+5 °C ... +10 °C

